



BAKER TILLY
DALAIVAN AUDIT

Audit assurance, property and business
valuation advisory services

Amarsanaa street-5, Bayangol district
Ulaanbaatar-16066, Mongolia
Phones: 70005401, 70005402
Fax: +976-70005403
E-mail: info@btdalaiivanaudit.mn
Web site: www.btdalaiivanaudit.mn

INDEPENDENT AUDITOR'S REPORT

TO: THE BOARD OF DIRECTORS OF DEVELOPMENT SOLUTIONS NGO

Our opinion

We have audited the accompanying financial statements of Development Solutions NGO, which comprise the statement of financial position as at December 31, 2020, the statement of activities and changes in net assets for the year then ended, the statement of cash flows for the year then ended and the notes to the financial statements, which include a summary of significant accounting policies.

In our opinion, the financial statements present fairly, in all material respects, the financial position of Development Solutions NGO as of December 31, 2020, and its statement of activities and changes in net assets and its cash flows for the year then ended in accordance with Accounting and Reporting Guidelines for NGO approved by Order No.386 issued by the Ministry of Finance in 2017 in compliance with International Financial Reporting Standards and the financial management principle, guidelines of the relevant donor financing organizations.

Basis for opinion

We conducted our audit in accordance with International Standards on Auditing (ISAs). Our responsibilities under those standards are further described in the *Auditor's Responsibilities for the Audit of the Financial Statements* section of our report. We believe that the audit evidence we have obtained is sufficient and appropriate to provide a basis for our opinion.

Independence

We have worked independently from Development Solutions NGO in compliance with the Code of Ethics for Professional Accountants issued by the International Ethics Standards Board for Accountants, and have fulfilled our other ethical duties and responsibilities in accordance with this Code.

Other information

Management is responsible for the other information. The other information comprises annual report of Development Solutions but does not include the financial statements and our auditor's report.

Responsibilities of Management and the Board of Directors to the financial statements

Management is responsible for the preparation and fair presentation of the financial statements in accordance with *Accounting and Reporting Guideline for NGO* and for such internal control as management determines is necessary to enable the preparation of financial statements that are free from material misstatement, whether due to fraud or error.

In preparing the financial statements, management is responsible for assessing Development Solutions NGO's ability to continue as a going concern pursuant to the going concern principle unless otherwise management either intends to liquidate or cease the operations of Development Solutions NGO, or has no realistic alternative but to do so.

INDEPENDENT AUDITOR'S REPORT (continued)


Those charged with the corporate governance will have responsibility for overseeing Development Solutions NGO's financial reporting process.

Auditor's responsibilities for the audit of the financial statements

Our objectives are to obtain reasonable assurance about whether the financial statements as a whole are free from material misstatement, whether due to fraud or error, and to issue an auditor's report that includes our opinion. Reasonable assurance is a high level of assurance, but is not a guarantee that an audit conducted in accordance with ISAs will always detect a material misstatement when it exists. Misstatements can arise from fraud or error and are considered material if, individually or in the aggregate, they could reasonably be expected to influence the economic decisions of users taken on the basis of these financial statements.

As part of an audit in accordance with ISAs, we have exercised professional judgment and maintained professional skepticism throughout the audit. We've also performed the following tasks to:

- Identify and assess the risks of material misstatement of the financial statements, whether due to fraud or error, design and perform audit procedures responsive to those risks, and obtain, audit evidence that is sufficient and appropriate to provide a basis for our opinion. The risk of not detecting a material misstatement resulting from fraud is higher than for one resulting from error, as fraud may involve collusion, forgery, intentional omissions, misrepresentations, or the override of internal control;
- Obtain an understanding of internal control relevant to the audit in order to design audit procedures that are appropriate in the circumstances, but not for the purpose of expressing an opinion on the effectiveness of Development Solutions NGO's internal control;
- Evaluate the appropriateness of accounting policies used and the reasonableness of accounting estimates and related disclosures made by management;
- Conclude on the appropriateness of management's use of the going concern basis of accounting and, based on the audit evidence obtained, whether a material uncertainty exists related to events or conditions that may cast significant doubt on Development Solutions NGO's ability to continue as a going concern. If we conclude that a material uncertainty exists, we are required to draw attention in auditor's report to the related disclosures in the financial statements or, if such disclosures are inadequate, to modify our opinion. Our conclusions are based on the audit evidence obtained up to the date of our auditor's report. However, future events or conditions may affect Development Solutions NGO's ability to continue as a going concern; and
- Evaluate the overall presentation, structure and content of the financial statements, including the disclosures, and whether the financial statements represent the underlying transactions and events in a manner that achieves fair presentation.



AUGUST 5, 2021



БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ

Аудит, баталгаажуулалт, хөрөнгийн болон
бизнесийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

Монгол Улс, Улаанбаатар хот-16066
Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5
Утас: 70005401, 70005402
Факс: +976-70005403
Э.П.хуудан: info@btdalaiwanaudit.mn
Вэб хуудас: www.btdalaiwanaudit.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ” ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Санал дүгнэлт

Бид 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүү байдлын тайлан, үр дүнгийн тайлан болон цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон гол чухал нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Хөгжлийн Шийдэл” ТББ-ын санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар “Хөгжлийн Шийдэл” ТББ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, тухайн жилийн үр дүн, цэвэр хөрөнгийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Сангийн Яамны 2017 оны 386-р тушаалаар баталсан Төрийн бус байгууллагын санхүүгийн тайлан, түүний тодруулгыг бэлтгэх заавар, холбогдох санхүүжүүлэгч донор байгууллагуудын санхүүгийн удирдлагын зарчим, зааварчилгааны дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага хэсэгт харуулсан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалтай бөгөөд зохистой гэж үзэж байна.

Хараат бус байдал

Бид Олон Улсын Ёс зүйн Хорооноос гаргасан санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу Хөгжлийн Шийдэл ТББ-аас хараат бус байж, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэлд Хөгжлийн Шийдэл ТББ-ын жилийн тайланг хамааруулах бөгөөд үүнд санхүүгийн тайлан болон аудиторын дүгнэлт тайлан багтаагүй.

Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь Төрийн бус байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагналын зааврын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага (үргэлжлэл)

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага, төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоохоор шийдсэнээс бусад тохиолдолд, тасралтгүй байх зарчмын дагуу Хөгжлийн Шийдэл ТББ-ын үйл ажиллагааг зогсолтгүй явуулах байгууллагын чадамжийг үнэлэх үүргийг хүлээнэ.

Байгууллагын засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагналыг байнга илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- ✓ Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- ✓ Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд байгууллагын дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ Хөгжлийн Шийдэл ТББ-ын дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- ✓ Байгууллагын ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- ✓ Хэрэв байгууллагын тасралтгүй байх чадавхад материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд Хөгжлийн Шийдэл ТББ-ын тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- ✓ Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.



БЭЙКЕР ТИЛЛИ
ДАЛАЙВАН АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

2021 ОНЫ 8 ДУГААР
САРЫН 5-НЫ ӨДӨР